



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн 4-р сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	7
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.23 № 283

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
 - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
 - 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
 - 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
 - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
 - 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**
-

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,108,213.68	129,712,062.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	122,108,213.68	129,712,062.46
351	Түүхий эд материал	111,008,147.63	119,572,063.41
35110	Тусгай зориулалттай материал	110,799,247.63	118,369,613.41
35130	Эм боох материал	208,900.00	1,202,450.00
354	Хангамжийн материал	11,100,066.05	10,139,999.05
35410	Бичиг хэргийн материал	3,434,693.05	4,055,733.05
35420	Аж ахуйн материал	4,402,300.00	2,241,350.00
35440	Түлш, шатах тослох материал	225,000.00	270,000.00
35460	Хүнсний материал	3,038,073.00	3,572,916.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,333,671,365.71	1,273,280,847.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,333,671,365.71	1,273,280,847.71
392	Биет хөрөнгө	1,177,946,365.71	1,117,555,847.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,180,762,902.07	1,180,762,902.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	(93,709,874.10)	(142,610,005.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,990,461.93	120,754,003.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,162,881.93)	(77,701,353.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,428,016.83	115,414,475.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(75,362,259.09)	(79,064,175.00)
393	Биет бус хөрөнгө	155,725,000.00	155,725,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	155,725,000.00	155,725,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,455,779,579.39	1,402,992,910.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,455,779,579.39	1,402,992,910.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,455,779,579.39	1,402,992,910.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	155,725,000.00	155,725,000.00
51101	Өмч - төрийн	155,725,000.00	155,725,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	583,204,663.17	530,417,993.95
51210	Өмнөх үеийн үр дүн	583,204,663.17	583,204,663.17
51220	Тайланг үеийн үр дүн	-	(52,786,669.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	471,880,873.64	471,880,873.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,455,779,579.39	1,402,992,910.17

Хэрлэн сумын 4-р цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	825,557,663.20	731,200,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,330,663.20	8,481,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	93,330,663.20	8,481,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,330,663.20	8,481,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93,330,663.20	8,481,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,227,000.00	722,719,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	643,293,600.00	639,687,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	643,293,600.00	639,687,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,000.00	1,191,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	836,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210,000.00	355,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,723,400.00	81,840,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,723,400.00	81,840,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	743,008,980.23	782,728,626.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743,008,980.23	782,728,626.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	692,974,997.76	697,665,587.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,478,968.00	440,767,953.00
210101	Үндсэн цалин	304,531,475.32	328,097,117.06
210102	Нэмэгдэл	96,838,339.68	75,004,633.94
210104	Урамшуулал	36,109,153.00	37,666,202.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,231,748.53	59,661,285.11
210201	Тэтгэврийн даатгал	38,966,802.95	42,058,115.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,430,188.49	4,654,611.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,187.53	3,579,149.10
210204	Ажилгүйдлийн даатгал	678,931.39	825,767.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,783,638.17	8,543,641.11
2103	Байр ашиглалттай хөлбөөтэй тогтмол зардал	82,330,993.00	77,111,912.23
210301	Гэрэл, цахилгаан	5,092,891.00	3,989,235.23
210302	Түлш, халаалт	71,743,000.00	68,149,225.00
210303	Цэвэр, бохир ус	5,495,102.00	4,973,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,419,348.14	8,826,321.02
210401	Бичиг хэрэг	520,300.00	519,600.00
210402	Тээвэр, шатахуун	275,000.00	455,000.00
210403	Шуудан, холбоо, нигэрнэтийн төлбөр	1,063,957.00	1,092,000.00
210404	Ном, хэвлэл	-	119,260.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	764,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,796,091.14	6,280,461.02
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	34,529,621.00	23,167,407.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,089,300.00	796,350.00
210502	Хоол, хүнс	33,212,431.00	22,289,167.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдгэл	227,890.00	81,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,951,750.00	3,877,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	1,951,750.00	3,877,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	159,000.00
210702	Дотоод албан томилолт	-	159,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,312,569.09	83,085,908.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,602,150.40	6,504,133.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	67,710,418.69	76,581,775.69

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,033,982.47	85,063,039.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,380,000.00	5,239,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,380,000.00	5,239,750.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,394,157.00	3,598,287.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,394,157.00	3,258,487.77
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	339,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,259,825.47	76,225,001.89
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,259,825.47	76,225,001.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	82,548,682.97	(51,527,926.91)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,258,742.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,258,742.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,258,742.31)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	82,548,682.97	(52,786,669.22)

Хэрлэн сумын 4-р цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,694,042.58	471,880,873.64	500,655,980.20	1,373,230,896.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,694,042.58	471,880,873.64	500,655,980.20	1,373,230,896.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	82,548,682.97	82,548,682.97
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,694,042.58	471,880,873.64	583,204,663.17	1,455,779,579.39
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	400,694,042.58	471,880,873.64	583,204,663.17	1,455,779,579.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,694,042.58	471,880,873.64	583,204,663.17	1,455,779,579.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүдэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	(52,786,669.22)	(52,786,669.22)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,694,042.58	471,880,873.64	530,417,993.95	1,402,992,910.17

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	732,227,000.00	722,719,700.00
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,227,000.00	722,719,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	643,293,600.00	639,687,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	643,293,600.00	639,687,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,000.00	1,191,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	836,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210,000.00	355,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,723,400.00	81,840,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,723,400.00	81,840,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	700,969,710.00	705,269,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,969,710.00	705,269,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650,935,727.53	620,206,660.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,478,968.00	440,767,953.00
210101	Үндсэн цалин	304,531,475.32	328,097,117.06
210102	Нэмэгдэл	96,838,339.68	75,004,633.94
210104	Урамшуулал	36,109,153.00	37,666,202.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,231,748.53	59,661,285.11
210201	Тэтгэврийн даатгал	38,966,802.95	42,058,115.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,430,188.49	4,654,611.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,187.53	3,579,149.10
210204	Ажил үйлдлийн даатгал	678,931.39	825,767.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,783,638.17	8,543,641.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,330,993.00	77,111,912.23
210301	Гэрэл, цахилгаан	5,092,891.00	3,989,235.23
210302	Түлш, халаалт	71,743,000.00	68,149,225.00
210303	Цэвэр, бохир ус	5,495,102.00	4,973,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,164,187.00	6,831,500.00
210401	Бичиг хэрэг	1,730,400.00	793,800.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,063,957.00	1,092,000.00
210404	Ном, хэвлэл	139,596.00	135,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	764,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,966,234.00	3,950,700.00
2105	Нормативт зардал	44,069,441.00	25,753,410.00
210501	Эм, бөндмөл, эмнэлгийн хэрэгсэл	2,880,800.00	1,632,400.00
210502	Хоол, хүнс	28,878,641.00	22,824,010.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	12,310,000.00	1,297,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,998,250.00	1,755,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	2,998,250.00	1,755,300.00
2107	Томилголт, зочны зардал	-	159,000.00
210702	Дотоод албан томилолт	-	159,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,942,140.00	7,158,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,942,140.00	7,158,300.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,033,982.47	85,063,039.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,380,000.00	5,239,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,380,000.00	5,239,750.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,394,157.00	3,598,287.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,394,157.00	3,258,487.77
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	339,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,259,825.47	76,225,001.89
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,259,825.47	76,225,001.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,257,290.00	17,450,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,257,290.00	17,450,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,257,290.00	17,450,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,257,290.00	17,450,000.00
223001	Бусад хөрөнгө	31,257,290.00	17,450,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(31,257,290.00)	(17,450,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	721,527,900.00	642,044,410.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	721,527,900.00	642,044,410.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	716,227,900.00	636,804,660.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,042,900.00	440,767,953.00
210101	Үндсэн цалин	291,284,600.00	328,097,117.06
210102	Нэмэгдэл	125,089,900.00	75,004,633.94
210104	Урамшуулал	37,668,400.00	37,666,202.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,525,000.00	59,661,285.11
210201	Тэтгэврийн даатгал	44,966,500.00	42,058,115.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,889,600.00	4,654,611.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,911,700.00	3,579,149.10
210204	Ажил гүйдлийн даатгал	977,900.00	825,767.97
210205	Эрүүл мэндийн даатгал	9,779,300.00	8,543,641.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,355,500.00	77,111,912.23
210301	Гэрэл, цахилгаан	7,200,000.00	3,989,235.23
210302	Түлш, халаалт	64,555,500.00	68,149,225.00
210303	Цэвэр, бохир ус	8,600,000.00	4,973,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,779,100.00	6,761,500.00
210401	Бичиг хэрэг	741,400.00	723,800.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	1,195,500.00	1,092,000.00
210404	Ном, хэвлэл	147,600.00	135,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутг	360,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,834,600.00	3,950,700.00
2105	Нормативт зардал	79,612,800.00	25,753,410.00
210501	Эм, бөлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,635,700.00	1,632,400.00
210502	Хоол, хүнс	76,674,800.00	22,824,010.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдгэл	1,302,300.00	1,297,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,585,200.00	18,920,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,500,000.00	17,450,000.00
210602	Тавилга	3,600,000.00	-
210604	Урсгал засвар	1,485,200.00	1,470,300.00
2107	Томилолт, зочны зардал	246,700.00	159,000.00
210702	Дотоод албан томилолт	246,700.00	159,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа	1,008,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,072,700.00	6,661,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	357,800.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,714,900.00	6,661,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,300,000.00	5,239,750.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,300,000.00	5,239,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,300,000.00	5,239,750.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	721,527,900.00	642,044,410.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	639,687,200.00	563,462,198.11
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	639,687,200.00	563,462,198.11
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,840,700.00	78,582,212.23
132001	Орон нутгийн төсвөөс	81,840,700.00	78,582,212.23

Хэрлэн сумын 4-р цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,191,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,191,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	852,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	70,000.00
210401	Бичиг хэрэг	-	70,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	285,000.00
210604	Урсгал засвар	-	285,000.00
2109	Бараа үйлчилгээний бусал зардал	-	497,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	497,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	339,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	339,800.00
213405	Товлоруулах шилжүүлэг	-	339,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,191,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,191,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	836,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	355,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор Б.Баярмаа, аудиторын туслах Б.Мөнхзул нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: "Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино" гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаа сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 743,009.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,430.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,944.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,786.7 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	122,108.2	129,712.1	7,603.9
Үндсэн хөрөнгө	1,333,671.4	1,273,280.8	(60,390.6)
Нийт хөрөнгө	1,455,779.6	1,402,992.9	(52,786.7)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	400,694.0	400,694.0	-
Хуримтлагдсан үр дүн	583,204.7	530,418.0	(52,786.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	471,880.9	471,880.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,455,779.6	1,402,992.9	(52,786.7)

Бараа материалын дансны үлдэгдэл 129,712.1 мянган төгрөг болж 7,603.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 39,746.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй орлого 8,481.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 32,313.7 мянган

төгрөгийн бараа материалыг зарцуулж, 8,309.7 мянган төгрөгийн бараа материал актласнаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,273,280.8 мянган төгрөг болж 60,390.6 мянган төгрөгөөр буурсан нь 17,450.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 27,699.9 мянган төгрөгийн хөрөнгө актласан байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 76,581.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогджээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 530,418.0 мянган төгрөг болж, 52,786.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлсөн байна..

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 94,357.0 мянган төгрөгөөр 12.0 буюу хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт 3,606.4 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 84,849.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 39,719.7 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл цалин нийгмийн даатгалын шимтгэл 6,718.5 хангамж бараа материалын зардал 2,406.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 1,926.1 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 875,060.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 153,532.4 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 721,527.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 50,211.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 9,097.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 85,500.6 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 721,527.9 мянган төгрөгөөр баталсанаас 639,687.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 81,840.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 639,687.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 81,840.7 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 642,044.4 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 76,225.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 3,258.5 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 642,044.4 мянган төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 13,274.9 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 53,850.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1,191.8 мянган төгрөгийн орлого орж, 852.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 339.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх онд аудитаар 1 зөвлөмж өгсөнөөс 100 хувь хэрэгжүүлсэн байна

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,678.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 9,678.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

4.4.1.Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 9,678.5 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
	Хэрлэн сумын 4-р цэцэрлэг	1	9,678.5								1	9,678.5
Дүн		1	9,678.5								1	9,678.5